

Майничи сонин Монголын эрх баригчдыг үргэлжлүүлэн “гүтгэсээр” л байна уу?



2011 оны 5 сарын 9-нд Монголын эрх баригчид эх нутагтаа цөмийн хаягдлыг булшлахаар Япон, АНУ-тай нууц хэлэлцээр хийж байгаа тухай дуулиантай мэдээ Японы Майничи сонинд нийтлэгдсэн. Түүний дараахан Гадаад Хэргийн Яамныхан үүрээ сандчуулсан шоргоолж шиг үймж, Г. Занданшатар сайд, тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд А. Ундраа, МонАтом компанийн захирал Бадамдамдин нар хэвлэл мэдээллийнхнийг дуудаж, хэвлэлийн хурал хийлгэж, сонинд ярилцлага өгч, “тэр бол буруу ташаа мэдээлэл” хэмээн үгүйсгэж, “Майничи сонинд залруулга хийнэ үү гэсэн захидал явуулсан” гэж олон нийтийг аргалсаар өнөөдрийг хүрсэн билээ.

<http://news.gogo.mn/r/87533>

<http://www.zuuniimedee.mn/modules.php?name=News&nid=591>

http://www.dailynews.mn/?vfile=30&vmet_id=19243&vmet_main=1017

Энэ талаарх мэдээлэл уншсан нэгэн уншигч ийм сэтгэгдэл үлдээжээ:

“Монгол улс чаддаг юм бол Майничи сониныг олон улсын шүүхэд өг л дөө! Хэрэв монголын талаас оролцоогүй байхад ингэж муухай гүтгэж байгаа юм бол олон улын шүүхэд ханд л даа, РОЙТЕРС, МАЙНИЧИ ШИНБҮН 2 Санхүүгийн хариуцлага хүлээх чадвартай маш том хэвлэл мэдээллийн байгууллага Монголын хошгируулагч, хашгируулагч, хулхиддаг улс төрийнхнөөс илүүтэйгээр баримт түшиж мэдээ бичдэг гадны сэтгүүлүүдэд би хувьдаа итгэж байна, Худлаа мэдээлэл бичвэл хариуцлага хүлээдэг тогтолцоо ажилладаг юм, Наадмаар, цагаан сараар тааруулж олны хэл ам татсан хууль баталдаг наад хэд чинь байдлыг саармагжуулж байгаад боломж л гарвал гэрээг үзэглэнэ, ЧАДДАГ ЮМ БОЛ ОЛОН УЛСЫН ШҮҮХЭД ӨГ Л ДӨӨ, Паушокыг дарсан шигээ асуудлыг шийд л дээ!” гэжээ
(<http://news.gogo.mn/r/87533>)

Тэгвэл нөгөө болдоггүй Майничи сонин өөрийнхөөрөө зүтгэсээр л байгааг доорх мэдээнээс үзнэ үү. Эсвэл А. Ундраагийн бичсэн захиа хүрээгүй юм болов уу?

Монголын засгийн газар үгүйсгэсээр байхад Пулицерийн шагнал хүртсэн, олон улсад нэр хүндтэй Японы 3 том сонины нэг болох Майничи сонин Монголын эрх баригчдыг үргэлжлүүлэн “гүтгэсээр” л байгаа бололтой. Тухайлбал, тус сонины 2011 оны 6 сарын 13-ны англи хэл дээрх хувилбарт нь дараах мэдээ нийтлэгджээ:

Цөмийн хаягдлыг хаяж булшлах нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал мөн

June 14, 2011 | Company Profile | Japanese Site

The MDN on Kindle: Your handy English news source.

The Mainichi Daily News

Get MDN news through Kindle. More info ▶

News Perspectives Features Arts & Entertainment Travel Weather

Editorial Sign of the Times Yoroku News Navigator Selected Columns

Perspectives

Disposal of nuclear waste should be made a top priority

In the June issue of the monthly journal Sekai (The World), life scientist Keiko Yanagisawa argues that nuclear power plants must not be operated as long as we do not know how to dispose of highly radioactive nuclear waste -- which can wreak havoc on human DNA.

Tetsuzo Fuwa, chairman of the Japanese Communist Party (JCP), is of the same view. Reading over the column he wrote in the party's daily paper Akahata (Red Flag), his position is presented in clear, unambiguous language.

Both Fuwa and Yanagisawa are alarmed that as a result of having continued the operation of nuclear power plants without any waste disposal measures in place, highly radioactive spent fuel has accumulated to breaking point.



In this June 9, 2011 photo released Saturday, June 11, 2011 by Tokyo Electric Power Co. (TEPCO), equipment inside the cesium absorption tower, part of the newly-built radioactive water processing facilities at Fukushima No. 1 nuclear power plant in Okuma, Fukushima prefecture, is shown. (AP Photo/Tokyo Electric Power Co.)

Photo Journal



Making a splash

In Focus

Daichi satellite photos show different faces of Earth

Olympics: Hiroshima formally pulls out of Olympic bid

Videos

Майничи сонин 2011-06-13

Орчуулсан Амарлин

Эх сурвалж:

<http://mdn.mainichi.jp/perspectives/news/20110613p2a00m0na001000c.html>

Секай (Дэлхий Ертөнц) гэдэг сар тутмын сэтгүүлийн 6 дугаар сарын дугаарт амьд ертөнцийг судлаач Кэйко Янагисава нь хүний ДНХ-г ноцтой гэмтээдэг өндөр хүчтэй цацраг идэвхт цөмийн хаягдлыг хаяж цэгцэлж сурахаас нааш хүн төрөлхтөн АЦС ажилуулах ёсгүй хэмээн өгүүлжээ. Японы Коммунист Намын (ЯКН) тэргүүн Тецузо Фува ч мөн ижил бодолтой нэгэн аж. Тэрбээр өөрийн намын гаргадаг өдөр тутмын Акахата (Улаан Туг) сонинд өөрийн байр суурийг маш тодорхой, ойлгомжтой хэлээр тайлбарлажээ.

Фува, Янагисава нарын хамгийн ихээр сэтгэл түгшиж буй гол асуудал бол цөмийн хаягдал. Хаягдлаа чухам хэрхэх талаар тодорхой шийдэлгүйгээр АЦС-

уудыг олноор нь барьж, ажиллуулсны үр дүнд цацраг идэвх өндөртэй цөмийн түлшний хаягдал хэт ихээр хуримтлагдсан байна.

Цөмийн түлшний хаягдал нь ашиглаагүй цөмийн түлшнээс хавьгүй их хортой хөнөөлтэй, тогтмол сэрүүн хэмд хадгалахгүй бол асар аюултай. Хаягдал түлшнээс дулаан ялгарах нь багассан хойно ч цацраг идэвхт туяа цацарсаар байдаг тул цөмийн хаягдал түлшийг хүн амьтнаас зайдуу газарт хэдэн зуун мянган жилээр хадгалах шаардлагатай болдог.

Одоохондоо дэлхий нийтэд цөмийн хаягдал булшлах байгууламж байхгүй тул цөмийн түлшний хаягдлыг АЦС-уудын дэргэдэх усан санд хөргөж түр хадгалдаг. Тиймээс ч саяхны ослын дараахан Фукушимагийн 1-р АЦС-ын усан сангийн ус ууршиж, хаягдал түлш халж, хайлж эхэлсэн тухай мэдээг сонсоод судсаар гүйх цус царцах мэт болж билээ.

Өнгөрсөн сард NHK телевизийнхэн “Мөнхийн зүг” (“Into Eternity”) нэртэй нэгэн гайхамшигтай баримтат киног давтан гаргасан. Тус кинонд цөмийн хаягдал түлшийг хадгалах анхны байгууламжийг Финлянд улсад барьж буй тухай гардаг. Төлөвлөгөө ёсоор бол тус байгууламж нь цөмийн хаягдлыг газрын гүнд 500 метрт булшилж, Европын Холбооны улсын аюулгүй байдлын дүрэм журмын дагуу 100 мянган жилийн туршид хүн амьтнаас тусгаарлах юм байна.

Хэдэн арван мянган жил өнгөрөхөд Финляндад, манай гариг ертөнцөд ч ямаршуухан соёл иргэншил ноёрхож байхыг бид хэлж мэдэхгүй. Өндөр хөгжилтэй соёлт нийгмүүд тэр үед мөхсөн байж ч болно. Ямар ч байлаа гэсэн бид ирээдүйн үеийнхэндээ газар ухаж болохгүй гэдгийг нь хэрхэн ойлгуулах вэ? Энэ захиасыг хүргэх баталгаатай арга одоог хүртэл олдоогүй байна.

Бид цөмийн хаягдлын асуудлыг цөмийн энерги ашиглаж, эрчим хүч үйлдвэрлэхээсээ өмнө нь шийдэх ёстой байсан гэдгийг дээрх кинонд дурьдсангүй. Тиймдээ ч цөмийн хаягдал хадгалах агууламж Финляндад ч, өөр хаана ч байсангүй.


Япончууд нэгэн цагт цөмийн түлшний хаягдлаа далайн гүнд хаяхаар төлөвлөж байсан ч олон улсын асар их шүүмжлэлд өртсөний улмаас газрын гүнд булахаар тогтсон билээ. Гэвч чухам ямар байгууламж, хаана байрлах тухай тодорхой шийдвэр гаргаагүй. Орон нутгийн засаг захиргааныхан бол нутаг дэвсгэр дээр нь ердийн нэг хог боловсруулах төв байгуулахад ч дургүй байдаг. Тэд бол “Цөмийн хаягдал гэв уу? Больё доо” гэх нь тодорхой.

Монголд цөмийн хаягдал булшлах агуулах барих тухай Япон, АНУ-ын яриа ил болоход зарим хүмүүс “Монголчууд өөрсдөө зөвшөөрвөл болох л асуудал” гэгцгээж байлаа. Гэвч үнэндээ энэ бол гол асуудал биш, тийм биз?

Балар эртний үеийн далайн хясааны хогноос авахуулаад Эдогийн үеийн хогны цэг хүртэлх замыг туулахдаа хүн төрөлхтөн өөрийн тарьсан хог хаягдлаа өөрөө арилгаж, цэвэрлэсээр ирсэн түүхтэй. Тэгвэл бид өнөөдөр эрчим хүчээр ангасанаасаа болж төлөв даруу байж, хоёр тал руугаа үл хэлбийн ямагт дундыг баримтлах эртний уламжлалт заншлаа гээхэд хүрэв үү? (*Мичико Ушиода, ахлах нийтлэгч*)

Ийнхүү нөгөө болдоггүй Майничи сонин өөрийнхөөрөө зүтгэсээр л байна. Хоёр янзын үнэн гэж байхгүй тул эсвэл Монголын эрх баригчдыг эх нутагтаа цөмийн хаягдал булшлуулахаар сэмхэн хөөцөлдөж байгааг илчилсэн Майничи сонины зөв эсвэл тус сониныг үндэслэлгүй юм бичсэн гэсэн А. Ундраагийн аль нэгнийх нь л зөв байж таарна.

[НҮҮР](#) [БЛОГ](#) [ФОТО](#) [ЗАР МЭДЭЭ](#) [ЗӨВЛӨГӨӨ](#) [ВИДЕО](#) [ЗАХИАЛГА](#)


ӨДРИЙН СОНИН
 www.DailyNews.mn

Мянгар, 6-р сар 14, 2011

[УЛС ТӨР](#) [ЭДИЙН ЗАСАГ](#) [НИЙГЭМ](#) [СОЁЛ УРЛАГ](#) [ГАДААД МЭДЭЭ](#) [ТАНАЙД ӨНЖЬЕ](#) [ӨӨР ӨНЦГӨӨС](#) [НИЙТЛЭЛ](#) [БИДНИЙ ТУХАЙ](#)

SMS зар : 155005 | helni vakum surgaitандаа etselt avch ehelle utas: 99101855, 70121855 | Zaisangin irish castletai barand. 100mkv 3 oooo bar 2 mashini zogsoltoin hamt zanna Gach

А.Ундраа: "Mainichi" сонин АНУ, Японы хог хаягдлыг Монгол Улс авна гэж үндэслэлгүй мэдээлэл гаргасан

Гадаад харилцааны яамны тусгай үүрэг гүйцэтгэгч, Элчин сайд, доктор А.Ундраатай ярилцлаа.

-Монголын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булаах гэрээ хийж байсан гэх мэдээлэл "Mainichi" сонинд нийтлэгдсэн. Үнэн чанартаа АНУ, Япон, Монгол гурван улсын дунд чухам ямар гэрээ хэлэлцээр хийгдэж байсан юм бэ?

-Манай улс цөмийн түлшний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болохын тулд АНУ, Япон улстай хантран ажиллах болонжийг судалж, гурван улс энэ талаар ярилцаж эхэлсэн нь үнэн. Энэ бол манай талын санаачилгаар ашигт малтмалаа аль болох үр өгөөжтэй ашиглах бодлогын хүрээнд эхэлсэн хантын ажиллагаа. "Mainichi" сонин АНУ, Японы хог хаягдлыг Монгол Улс авах гэж буй мэтээр бичсэн нь үндэслэлгүй мэдээ юм. Миний мэдэж байгаагаар хэзээ ч АНУ, Японы зүгээс манайд хандаж цөмийн хаягдлаа манайд булшлах тухай асуудал тавиагүй. Хангийн гол нь Монгол Улс гадны хог хаягдлыг оруулж ирэх нь хуулиар хориглосон зүйл. УИХ-аас 2009 онд Цөмийн эрчим хүчний тухай хууль болон цөмийн салбарыг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг баталсан. Мөн Засгийн газраас цөмийн салбарт гадаад орнуудтай хантран ажиллах хөтөлбөрийг баталж, цөмийн эрчим хүч болон цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах чиглэлээр анхны гарга эхэлж, энэ салбар дөнгөж эхлэл шатандаа явна. Энэ бодлого чиглэлийн хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай хантран ажиллах эхлэл тавигдаж байна. Засгийн газраас ураны ашигт малтмалыг боловсруулан аль болох нэнүү өртөг шингээн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох зорилт тавин ажиллаж байна.

-Манай улс өөрсдөө цөмийн түлш хийх тухай яригдаж эхлэхтэй давхцан Японы "Mainichi" сонинны сурвалжлагч Монголд ирж сурвалжлага хийсэн нь цаанаа ямар учир зорилготой гэж үзэхээр байна?

Шинэ мэдээ | Их уншсан | Аргаас

Шинэ жилийн балаг одоо ч үргэлжилсээр...
Өнөөдөр 13:30:54

ЕНХАУ-ын Сэн-чун дүүргийн жагсаал
Өнөөдөр 13:28:28

Сэлэнгийн чиглэлд зөвхөн орой, галт тэрэг явна
Өнөөдөр 13:26:07

Хэдэн төгрөгөөр нааданлах вэ?
Өнөөдөр 11:44:02

Мальен гоц халдварт боон өвчөн гарчээ
Өнөөдөр 11:43:32

Улаанбаатар-Зүүнхараа чиглэлийн галт тэрэг зорчихгүй
Өнөөдөр 11:43:06

М.Кадаафи Илхаминөвтэй шатар тоглоо
Өнөөдөр 11:39:45

Туркийн парламентын сонгуулийн урьдчилсан дүн гарчээ
Өнөөдөр 11:39:19

Осана бие Гадены цогцлыг хайх гэнэ
Өнөөдөр 11:38:53

Монгол улсын засгийн газар үнэхээр гэм буруугүй нь үнэн юм бол юунд ингэж гүтгүүлж сууна вэ?

ЧАДДАГ ЮМ БОЛ ОЛОН УЛСЫН ШҮҮХЭД ӨГ Л ДӨӨ!